

Д.НАЦАГДОРЖ БОЛ ХХ ЗУУНЫ ШИНЭ ҮЕИЙН СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭГЧ МӨН

М.Саранцэцэг, доктор
МУБИС-ийн НХУС-ийн Нийгмийн ухааны тэнхимийн багш

Abstract: At the beginning of the twentieth century, the spiritual worldview of the Mongols co-existed in the minds of the Mongols. The social, political, and spiritual life of the Mongols have been profoundly changed. The purpose of this change in the new society and the minds of the Mongols were to deliver the feudal religious views. Mongolian nomadic culture, more specifically, their mentality have been inherited up to the present. Our spiritual values were the love of nature and religion. The values of art and literature play an important role in this change. D.Natsagdorj, a Mongolian enlightener, played an important role in the cognitive development and intellectual culture of the Mongols. Also, the social failures in the artworks attract people's attention.

Түлхүүр үг: Оюун санааны өөрчлөлт, уламжлалт үнэт зүйл, шинэ соёл, давуу хүсэл зориг, орчуулгын бүтээл

Удиртгал

ХХ зууны эхэн гэхэд Монголчуудын оюун санааны ертөнцөд олон янзын үзэл баримтлал сүлжилдэн оршиж байсан бөгөөд түүнийг аль нэг үзэл баримтлалыг иш болгон тайлбарлахад туйлын төвөгтэй. Судлаач доктор (Sc.D) Д.Дашпүрэв "... дэвшилт ардчилсан болон хувьсгалт ардчилсан үзэл, национализм хийгээд хөрөнгөтний үзэл суртлын янз бүрийн хэлбэр, шашин-феодалын үзэл суртал арай сүүлд социализмын үзэл санаа зэрэг урсгал Монголд оршин тогтнож олон түмний оюун санааны амьдралд тодорхой нөлөө үзүүлж байжээ." (2005, х.57) гэж тэр үеийн

Монголын оюун санааны ертөнцийг дүгнэсэн байдаг. Гэвч энэ үед шашин-феодалын үзэл нь нийгмийн бүхий л давхрагад ноёлогч шинжээ хадгалсан хэвээр байсан юм.

Үндсэн хэсэг

ХХ зуунд хүн төрөлхтөн, түүний дотор монголчуудын хувьд нийгэм, улс төр, оюун санааны амьдралд гүнзгий хувьсгалт өөрчлөлт гарчээ. Энэхүү хувьсгалт өөрчлөлтийн гол зорилго нь шинэ, цоо шинэ нийгмийг /ардын ардчилсан, социалист/ байгуулах, үндсэн хэрэглэгдэхүүн нь ард түмний оюун санааг шашин-феодалын үзлээс чөлөөлөх асуудал байлаа. Монголчууд бид хэдийгээр нүүдлийн соёл иргэншилтэй боловч суурьшмал, тогтонги сэтгэлгээг өвлөн уламжилсан ард түмэн. Бидний уламжлан ирсэн үнэт зүйл нь нэг талаас байгаль эхийг бишрэх, нөгөө талаас шашны зан үйлийг шүтэх явдал байв.

Энэхүү үнэт зүйлийг өөрчлөхөд урлаг, уран зохиол юу юунаас эрхэм чухал. Нэг үгээр хэлбэл хүний язгуурын төгс шинжийг бүрдүүлэх, хүнийг хүн болгодог сэтгэл зүйн олон хүчин зүйлийг чухам л урлаг хүн төрөлхтөнд өвлүүлэн удамшуулсаар ирсэн. "Хүмүүс нийгмийн ямар нэг түүхэн том өөрчлөлтийн босгонд тулан ирснийг ухаарахын хирээр урлагт тавьсан улс төрөөс шалтгаантай үзэл суртлын хатуу хяналтын тогтолцоог эвдэн ардчилах, шинэ цаг үед тохирсон урлагийн шинэ үнэт зүйлийг хүсэн хүлээж болно" (Галбаатар, 2006, х.186). Ингэхийн тулд юуны өмнө уламжлагдан ирсэн үнэт зүйлийг өөрчлөх нь нэн чухал юм.



Өөрөөр хэлбэл, нүгэл буян, үйлийн үр, хойд төрөл гэх мэт шашин, зан үйлийн дүрслэлээс хүний сэтгэлийн дотоод ертөнц рүү хандаж, хүн, хүний мөн чанар, амьдралын утга учир, байгаль ба хүний сэтгэлийн далд холбоо зэрэг ойлголтыг өргөн дэлгэр харуулахын зэрэгцээ хүний амьдралын гэрэл сүүдэр, баяр гуниг бүхнийг өөртөө агуулсан сэтгэлийн гүн ертөнцөд нэвтэрч, өөрийгөө болон амьдралыг зөв ухаарах явдал байв.

Д.Нацагдорж оюун сэтгэлгээний энэхүү өөрчлөлтийн үйл явцад өөрийн нөлөөг үзүүлж чадсан юм. Нийгэм түүхийн их үйл явц, өөрчлөлт дэвшлийг даган оюун санааны амьдралд ч хуучнаас шинэд дэвших, зөрчил тэмцэл бий болдог нь зүйн хэрэг. Өөрчлөгдөн буй нийгэм нь сонгодог бичгийн хэл, ардын аман зохиолын хуучин арга, хэлбэр маягийг шинэ үзэл бодол, шинэ нөхцөл байдалд нийцүүлэн шинэчилж баяжуулахыг шаардсан. Түүнчлэн хүн байгалийн төгс шүтэлцээ, үндэсний өвөрмөц онцлогоос гадна эрх чөлөөт тайван амьдрал, баян дэлгэр нутагт монголчууд үеийн үед эзэн байж, төрт ёсоо дээдэлж ирсэн хийгээд мөнхөд орших цогц утгыг бэлгэдсэн зохиол бүтээлүүдийг бичиж байв. Энэ үеэс эхлэн шинэ үзэл санаа бүхий зохиол бүтээлүүд бий боллоо.

“Аливаа хөгжиж байгаа амьд уран зохиол бүр нийгмийн хөгжлийн тодорхой үе шат бүрд шилжилтийн өвөрмөц үеийг туулдаг түгээмэл хуультай. Тодорхой улс үндэстний урлаг, уран зохиолд шилжилтийн үе тохиолдох нь тухайн улс орны нийгэм-улс төр-эдийн засаг-соёлын системийн цогц шинэчлэлтэй уялдан гарч ирдэг үзэгдэл юм.” (Галбаатар, 2006, х.20). Д.Нацагдоржийн уран бүтээлийн эхэн үеийн зохиолууд нийгмийн амьдрал, хувь хүмүүсийн хоорондын харилцааг дэлгэн харуулж, шудрага бус байдал, тэгш бус ёсыг буруушааж, үгүйрэл хоосрол, амьдралын зэрлэг харанхуйг уудлан илчилж, түүнд жигшин дургүйцэх өнгө аястай байлаа.

XX зуунд өрнө дахинд ихээхэн нэр хүнд олсон, орчин үеийн хүн судлалын томоохон төлөөлөгч, философич, сэтгэл

зүйч З.Фрейдын психоанализийн үзэл баримтлалаар бол ерөөс хүн гэгч амьтан өөрийгөө бодох /амиа бодох/, өөрийнхөө аливаа хэрэгцээг, тэр дотроо биологийнхоо хэрэгцээг хангахад түлхэж байдаг “дотоод далд ухамсрынхаа” жолоодлогод байдаг бөгөөд, нэр төр, өндөр албан тушаал, эрх мэдэлд шунах, баяжих, идэх уух хүсэл сонирхол нь бүгд энэхүү “далд ухамсраар” зохицуулагдаж байдаг. Гэвч энэхүү далд ухамсрыг ялан дийлэх хүч чадал нь зориг тэвчээрийг гаргаж чаддаг бөгөөд, энэ бол хүний ухамсрын бас нэг онцгой тал болох “давуу хүсэл зоригийн ухамсраас” шалтгаалдаг байна. Ийм давуу хүсэл зоригийн ухамсар нэн ялангуяа уран бүтээлч хүмүүс, томоохон сэтгэгчдэд илүү заяах бөгөөд энэхүү “давуу хүсэл” зориг нь онцгой зан чанар, онцгой авъяас билгээр илэрдэг.” (С.Энхбаяр, 2004) гэж тэмдэглэсэнчлэн Д.Нацагдорж нь өөрийн давуу хүсэл зорилгодоо хөтлөгдөн нийгмийн гажуудал, улс төрийн хийрхэлийн эсрэг бүтээлээ туурвих болжээ. Ийнхүү амьдран буй нийгэм улс төрийн тогтолцоонд дургүйцэж, шинэ гарц хайж байсан нь түүнийг хувь заяаны эрс эргэлтийн босгонд хүргэсэн юм.

“Аливаа улс төрийн хөдөлгөөн эхэндээ үерлэсэн их мөрөн мэт хөөсрөн ай саваа тэлэн оволздог. Харин дараа нь тэрхүү ус тогтнож, хөөс нь буухын цагт буурин дээр нь шинэ маягийн хүнд суртлын лаг шавар үлддэг.” (Галбаатар, 2006, х.247) хэмээн Ф.Кафка нэгэнтээ тэмдэглэж байсанчлан Монголын оюун санааны ертөнц нь тухайн үеийн нийгэм-улс төрийн байдалд хавчигдан байсныг энэ үеийн бүтээл туурвилаас харж болдог. Тухайлбал: Нийгэм дэх дарангуйлал, хүнд суртлын үл үзэгдэх хэлбэрүүд хийгээд хот хөдөөгийн ялгаа, хүний эрх, эрх чөлөө, ёс суртахуун зэрэг өөр хоорондоо холбоо бүхий асуудлыг сэтгэл зүйн учир шалтгаантай уялдуулан ертөнцийг үзэх үзэл, нийгэм- иргэний байр сууриа зохиол бүтээлдээ гүнзгий тусгах болжээ.

1930-аад оноос эхлэн Д.Нацагдорж гадаадын (орос, герман, америк) зохиолуудыг орчуулж эхлэсэн байдаг. Д.Нацагдоржийн хувьд орчуулга хийх нь эртний улбаатай

гэж үзэх бүрэн үндэстэй. Тэрээр урьд өмнө нь хятад, манж, төвд, энэтхэг зэрэг хэлнээс хөрвүүлсэн олон зуун дэвтэр үзэж, тэдгээрийн үг найруулгыг өөртөө шингээн авсан явдал нь түүний зохиол бүтээлээс илт харагдах бөгөөд тэдгээр хэлнээс орчуулга ч хийж байжээ.

Түүхийн эх сурвалжаас үзвэл: “1922 оны 4-р сард МХЗЭ-ийн Төв Хорооноос Москва хотноо Дорно дахины хөдөлмөрчдийн коммунист их сургуульд суралцуулахаар арван таван гишүүнийг нэр заан томилоход Д.Нацагдоржийн нэр багтаж байжээ.”(МАХН-ын Төв Архив. Ф.3, Д.1, ХН.174, Х.110). Улмаар 1925 оны 8-р сарын 14-ний өдөр хуралдсан Намын Төв Хорооны Зохион байгуулах зөвлөлийн тавдугаар хурлаас” Ленинград хотноо сургуульд орох учираа харьяат төв хорооны орлогч гишүүн ба шалган цэвэрлэх комисс, үйлдвэрчний эвлэлийн бага комиссоос тус тус чөлөө олгомуй хэмээсэн Нацагдоржийн өргөдлийг хэлэлцээд, сайшаан зөвшөөрч, чөлөө олгон сургуульд явуулахаар тогтжээ.”(МАХН-ын Төв Архив. Д.1, ХН.366, Х.31).

Ингэж Д.Нацагдорж нь ЗОУ-ын Ленинград хотноо Зөвлөлтийн улаан армийн нам, улс төрийн удирдах ажилтныг бэлтгэх төв - Н.Г.Толмачёвын нэрэмжит Цэргийн улс төрийн академийн дэргэдэх нэг жилийн курст орж, суралцах хугацаандаа орос хэл бичигт нилээд шамдсан байна. Түүнчлэн “1929 оны хавраас 1930 оны хавар хүртэл төмрийн заводод орчуулагч хийж байжээ.”(УТТА. Ф.23, Д.2, ХН.179) гэснээс дүгнэн харвал тэрээр ажил хэргийн шинжтэй орчуулгаас гадна иргэний шинжтэй, утга уянгын агуулгатай зохиол бүтээл орчуулах арвин их туршлага хуримтлуулсан нь илт байна.

Ер нь хаана хүч хэрэглэнэ тэнд үнэн, шудрага ёс, энэрэн нигүүсэх сэтгэл, итгэл байх үндэсгүй билээ. Ямар ч үзэл бодолгүй хүн байдаггүйн нэгэн адил ямар ч тодорхой зорилго чиглэлгүй, үзэл санаа агуулаагүй зохиол бүтээл гэж үгүй. Тэр тусмаа орчуулах гэж буй зохиол бүтээл бүр ямар нэг үзэл санааг агуулах нь зүйн хэрэг. Аливаа нэг зохиол бүтээлийг орчуулахад орчуулж буй зохиолын

зохиогч, орчуулж байгаа орчуулагч хоёрын үзэл санаа ойр төс байх нь чухал бөгөөд ийм ч учраас Д.Нацагдорж А.С.Пушкины зохиол бүтээлээс орчуулж байжээ. А.С.Пушкин үнэн ариун нэр төрийн төлөө, хаант засгийн бурангуй ёсыг эсэргүүцэн шүлэг яруу найргаа туурвиж байсан. Тийм ч учир А.С.Пушкины зохиолуудаас нийгмийн дарлал мөлжлөг, бурангүй байдал, хүний дотоод сэтгэлийн хувирал, хувь хүний ёс суртахууны эвдрэл задралыг харуулсан «Гилбэрийн хатан», «Анчар», «Хоригдол», «Буудалцсан нь», «Сэрэхүй», «Газар далай хоёр» зохиолуудыг орчуулсан байдаг. /Ц.Дамдинсүрэн, Б.Ренчин, Ц.Цэдэнжав /1913/, Х.Пэрлээ /1911/ нарын хамт монгол уншигчдад А.С.Пушкиний уран бүтээлийн үүдийг нээж өгсөн/.

Д.Нацагдоржийн орос хэлнээс орчуулсан орчуулгыг эрдэмтэн судлаачид хэл шинжлэл, утга зохиол талаас нь дараах байдлаар үнэлэн дүгнэсэн байна. Тухайлбал: К.Яцковская “Д.Нацагдорж Монгол зөвлөлтийн ард түмний хоорондын, тухайлан монгол оросын соёл хоорондын хэлхээ холбооны үндсийг анхлан тавилцсан уран бүтээлч хүн гэж ам дүүрэн хэлж болно.”(1978, х.95) хэмээсэн бол судлаач Д.Наваансүрэн Д.Нацагдорж өрнө дорны тэгш боловсролтой сэхээтний нэг байсан бөгөөд орос, герман, манж зэрэг хэл бичиг мэддэг байсны үрээр дэлхийн дэвшилт утга зохиол болон орос зөвлөлтийн утга зохиолын баялаг туршлагаас суралцаж, А.С.Пушкины «Анчар», «Хоригдол», «Буудалцсан нь», Ги Де Мопассоны «Аглагч», Эдгар По-гийн «Алтан цох» зэрэг зохиолыг орчуулж уншигч олондоо өргөн барьжээ гэж дүгнэсэн байдаг. Түүнчлэн “... орос хэлнээс яруу найраг хөврүүлэхдээ уг зохиолын санааг нэмж хасалгүй бүрэн гүйцэт гаргахаар оносон үг сонгон авч, шүлэг зохиолын хэлбэр дотоод ур яруу сонсголыг уншигчдын сэтгэлд буух зураглалыг бүхэл хэвд нь үлдээхийг эрхэмлэн үздэг байжээ.” (“Орчуулах эрдэм”.1978), “... орчуулагч өөрөө яруу дүрслэлийн өргөн дэлгэр мэдлэгтэй, орос хүний зан заншил, ахуйг сайн мэддэг, орос хэлний үгийн сан, хэлзүйн аливаа төвөгтэй үзэгдэлд захирагдан



баригдахааргүй гүн бат мэдлэг эзэмшсэнтэй холбоотой.” (Суу билигт зохиолчийн сод нэгэн авъяас.1981) гэх мэт эх сурвалжид дүгнэсэн байна.

«Гилбэрийн хатан», «Анчар», «Хоригдол», «Буудалцсан нь», «Сэрэхүй», «Газар далай хоёр» зэрэг зохиолыг орчуулснаар монголын нийгэмд бий болсон бурангуй явдлын зүгт ард түмний анхаарлыг хандуулах гэсэн Д.Нацагдоржийн гол санаа оршиж байлаа.

1927 онд Д.Нацагдорж “... европын аль чухал сайны нь олж сураад дараа харъяат улс төр, ард түмэндээ тус хүргэсүгэй хамаасан (хэмээсэн???) учир...” (Цэдэв.1967) гэж бичиж байсанчлан европын, тэр тусмаа германы сэтгэлгээний өвөрмөц бичигдсэн зохиол, түүнчлэн нийгэм, эдийн засаг, улс төрийн томоохон бүтээлүүдийг монголын ард түмэнд толилуулах болсон. Жишээлбэл: Эдгар По «Алтан цох», Мопассаны «Эх орноо хайрлагч» зэрэг үргэжилсэн зохиол, Карл Марксын «Капитал» зэрэг зохиолыг орчуулсан юм.

1926 оны 9-р сарын 11-ний өдөр хуралдсан Намын Төв Хорооны Зохион байгуулах зөвлөлийн гишүүдийн хурлаас гадаадын сургуульд суралцахыг хүсэгчдийн асуудлыг авч хэлэлцээд, Герман улсын сургуульд Нацагдорж, Пагмадулам нарын 6 хүнийг шинээр нэмэн илгээж, улс орондоо чухал хэрэгцээтэй мэргэжил эзэмшин ирэх итгэл, хариуцлага ноогдуулжээ.”(МАХН-ын Төв Архив, х.104).

Улмаар “Герман улсад одоо суралцах залуус Улаанбаатараас 1926 оны 10-р сарын 14-ний өдөр өртөөгөөр мордон, Алтанбулаг хүрч, цааш Зөвлөлт Холбоот Улсыг дамжин Германы Берлин хотноо хүрэлцэн очжээ.”(Очир, Дашням.1996.) гэж А.Очир нар хамтын бүтээлдээ тодотгож өгчээ. Энэ тухай 1935 оны анкетдаа Д.Нацагдорж “Берлин хотноо герман хэл бичгийн институтийг дуусгаж, Лайпциг хотноо сонин сэтгүүл ба дорно дахиныг судлах институтад гурван жил явсан.” (УТТА. Д.Нацагдоржийн хувийн фонд, задгай материалд) гэж бичсэн байдаг. Энэ бүхэн нь Д.Нацагдоржийг герман

хэлний асар өндөр боловсрол эзэмшсэнийг илтгэх нэгэн баримт юм.

1930 он бол Д.Нацагдоржийн амьдралд ч , оюун санаанд ч асар их өөрчлөлт бий болсны улмаас нийгмийн төдийгүй оюун сэтгэлгээнд томоохон өөрчлөлтийг бий болгосон юм. Өөрөө өөрийгөө ойлгох гэсэн үзэл нь сэтгэлгээний эрэл хайгуул болон хувирч, түүний илрэл болгон А.С.Пушкины зохиол бүтээлийг орос хэлнээс орчуулахын зэрэгцээ Эдгар По-гийн «Алтан цох», Мопассаны «Эх орноо хайрлагч» зэрэг үргэлжилсэн үгийн зохиолыг орчуулсан нь оюун ухааны эргэлтэд орж, утга агуулга сэтгэлгээний шинэлэг талыг нээж өгсөн байна.

“Хүний оршин тогтнохуйн үндсийн үндэс бол сэтгэлийн ариусал, дотоод ертөнцийн орон зай, түгээмэл хайр, нинжин сэтгэл, аугаа их шашин, аугаа их бишрэл, аливаа сайхныг дээдлэх нөхцөл буюу товчоор томьёолж хэлбэл соёл юм.” (С.Энхбаяр. 2004. х.55). Д.Нацагдорж нь герман орны нийгмийн хөгжил, ард түмний аж амьдрал, зан заншилтай танилцан өөрийн оронд германы сэтгэлгээний соёлын хөгжлийг зохиол бүтээлээр нь дамжуулан таниулахад тодорхой хувь нэмрээ оруулсан юм. Энэ тухай Д.Зебев “«Шинэ үзэгдэл, өөр амтанд умбан» мэдлэгийн хүрээгээ тэлж, өрнө дахины зохиолчдын бүтээл туурвилтай танилцан, түүнээс орчуулсан хийгээд суралцсан явдал нөлөө үзүүлсэн нь эргэлзээгүй юм. Зөвлөлт, Герман орны амьдралыг монгол уншигчдад танилцуулах эхлэлийг тавьсан.”(2000, х.195-197) гэж Д.Нацагдоржийг үнэлжээ.

Хэдэн зууны турш монгол угсаатны оршин тогтнох үндэс болж ирсэн нүүдлийн соёл иргэншил нь тэдний нийгмийн ахуй болон соёлын харилцаатай салшгүй холбоотой хөгжиж ирсэн. Энэхүү хөгжлийн холбоо нь урлаг уран зохиолд тусгалаа олсон байдаг. Судлаач Д.Галбаатар “Уран зохиол бол урлаг төдийгүй амьдрал өөрийнхөө жинхэнэ дүр төрхөөр байгаа нь тэр юм.”(Урлахуйн галыг бадраагч зул эндүүрлийн гэмийг ариусгагч. 2006. х.

397-398) хэмээсэн нь тохиолдлын ойлголт биш юм. Уран бүтээлийн аливаа арга үүсч хөгжих, хувьсан өөрчлөгдөх, халагдаж солигдох, салбарлан задрах үйл явц зөвхөн урлаг уран зохиол төдийгүй нийгэм, түүх, улс төрийн амьдрал дахь өөрчлөлт, тухайн үндэстний зан заншил, ертөнцийг үзэх итгэл үнэмшилтэй холбоотой нарийн нийлмэл үйл явц болохыг эрдэмтэн судлаачид онцолсон байдаг.

Нийгэм улс төрийн амьдралд өөрчлөлт гарч, хуучны туйлын хүслэн, сэтгэлгээний хэв маяг замхарч, шинэ үнэн зүйл бүрэлдэх нөхцөл бий болсон 1930-аад оны эхнээс, бүр тодруулбаас 1931 оноос эхлэн Д.Нацагдорж герман хэлнээс нийгэм-эдийн засаг, улс төр, уран сэтгэмжит зохиолуудыг орчуулах болсон нь нийгмийн шаардлага байв. Тухайлбал, К.Н.Яцковская “Нацагдорж Шинжлэх ухааны хүрээлэнд ажиллаж байх үедээ монголыг судлагч том эрдэмтэн Ц.Жамсарановтай хамтран ажилласан. Тухайлбал Нацагдорж түүний удирдлагаар К.Марксын «Капитал»-ын нэгдүгээр ботийн эхний хэсгээс герман болон орос хэлээр хэвлэгдсэн номыг нь ашиглан орчуулжээ.”(Дашдоржийн Нацагдорж. 1976. х.46) гэсэн анхны эрдэм шинжилгээний дүгнэлтийг үндэс болгон “Д.Нацагдорж «Капитал» зохиолыг орчуулж байхдаа ч «Коминтерны мөрийн хөтөлбөрийг» судалж, «Дэлхий дахины байдал»-ыг сонирхон «Октябрийн хувьсгалын 15 жилийн ойд зориулсан илтгэл» бичилцэж, нийгмийн хувьсгал ертөнцийн гүн рүү жинхэнэ материалист үзлээр хандаад зогсоогүй монголын ирээдүйг гардан байгуулагчдад өөрийн дуу хоолойгоор уриалсан билээ.” (Их зохиолч ертөнцийг хэрхэн үзэж байсан бэ?, 1978, х.207) гэж судлаач Г.Гэндэнсүрэн онцолсон бол судлаач Д.Наваансүрэн “Мөн нам улсын улс төр, эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгын үүднээс К.Марксын «Капитал»-ын тэргүүн ботиос нь орчуулалцаж байжээ.” (Монголын орчин үеийн утга зохиолыг үүсгэн бүтээгч, 1978. х.9), судлаач Б.Содном судалгааны бүтээлдээ “1931 оны намар Ерөө голын хавьд Ж.Цэвээнтэй Карл Марксын

«Капитал»-ын нэгдүгээрийн хэсгээс орчуулахад бичиж, бас уг герман хэлнээс нь харж, утга санааг Цэвээнд хэлж зөвлөлдөн байхдаа...”(Д.Нацагдоржийн зарим уран зохиолын судалгаа, 1980, х.58) гэж эрдэмтэн судлаачид өөр өөрийнхөө судалгаатай уялдуулан бичиж байв. Дээрхи судалгаанаас ажиглавал: нэгдүгээрт, Ж.Цэвээний удирдлага дор орчуулсан. Хоёрдугаарт, Ж.Цэвээнтэй зөвлөлдөн Д.Нацагдорж орчуулсан гэсэн дүгнэлтийг хийж болох байна. Харин түүхийн эх сурвалжаас харвал “... үүнийг үзүүлэгч тус хүрээлэнгийн түүх ба соёл боловсролын ангийн эрхлэгч Цэвээн Жамсранов ба түүний бичиг хэргийн нарийн бичгийн дарга Нацагдорж нарын хүмүүс ... Карл Марксын хувьсгалын зохиол дэвтрийг орчуулах зэргийн шинжилгээ эрдмийн хэргээр одсон болох тул ... гарын үсэг зурж, тамга дарсан үнэмлэх бичиг шийтгэн олгов. Эрхлэсэн түшмэл Ядамсүрэн” (УТГА. Ф.23, Д.2, ХН.9) гэсэн байдаг. Иймд Д.Нацагдорж нь Ж.Цэвээнтэй хамтран К.Марксын «Капитал» зохиолыг орчуулсан байна. Үнэн хэрэгтээ “Капитал” зохиолыг орчуулах нь түүхэн шаардлага байсан гэж үзэж байна. Учир нь монголчууд бид хэзээнээсээ л нүүдлийн соёл иргэншилтэй ард түмэн. Суурин соёл иргэншлийн үндсэн мөн чанар болсон таваар-мөнгөний харилцааны асуудал бидний хувьд шинэ ойлголт байсан юм. Түүнчлэн Д.Нацагдорж монголын түүхтэй холбогдсон нэлээд орчуулга хийсэн бөгөөд энэ тухай түүхийн хүрээлэнгийн Д.Нацагдоржтой холбогдон материалуудад байдаг. “Германы профессор Альберт хуучин франц хэлнээс нь товчилсон “Их хааны ордонд” нэртэйгээр герман хэлэнд буулгасан тэр товч орчуулгыг Д.Нацагдорж 1930 оны 11-р сарын 26- нд монголчлон төгсгөсөн байна.” (Их хааны ордонд. Итали улсын иргэн Марко Пологийн Төв ба дундад улсаар аялан явсан тэмдэглэл. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн номын сангийн гар бичмэлийн хөмрөгт) гэсэн энэхүү баримт нь түүнийг түүх, замын тэмдэглэл, аялагчдын сэтгэгдэл зэргийг орчуулж байсны илрэл юм.

Өмнө өгүүлсэнчлэн, Д.Нацагдоржид



1935 онд Америкийн зохиолч Эдгар По-гийн «Алтан цох» зохиолыг герман хэлнээс орчуулах нь зайлшгүй болохыг түүний сэтгэлгээний эрэл хайгуул ойлгуулсан. Энэ тухай Шинжлэх Ухааны Хүрээлэнгийн тэргүүлэгчдийн 1935 оны 6-р сарын 11-ний хурлын тушаалаар “Түүхийн тасгийн эрхлэгч Нацагдоржоос нөхөр Ринчений захисан ёсоор ... Аллан По-гийн «Алтан цох» хэмээх зохиолыг герман хэлнээс орчуулан ... гүйцэтгэснийг хянан тогтоож, зохих хөлсийг олгоно уу хэмээснийг хэлэлцээд, зүйтэй тул ёсоор болгон ... олгохоор тогтов.”(УТТА. Ф.23, Д.2, ХН.139) гэжээ.

Эдгар По-гийн «Алтан цох» зохиолын оршил өгүүлэлд тэрээр “По аваас, тооны ухаанд нэвтэрхий хүн байсан нь зохиосон зүйлд нь гүн бөгөөд нарийн, ямагт хүний сэтгэлд оршгүй бэрхтэй зүйлийг бичнэ. Бичсэн зүйл нь ... даруй дэлхий дахины яруу найруулгын эрдэний санд үнэлэгдэн, олон гадаадын хэл дээр орчуулагджээ. Энэхүү «Алтан цох» хэмээх зохиол үзвээс, маш нарийн нууц зүйлийг хүний ухаанаар ухаж болохыг утгачлан, зөвхөн өөрийн ухаанаар зохиогоод, мөн өөрийн ухаараан тайлахын хамт шинжлэх ухааны чанарыг илэрхийлсэн.”(Эдгэр По. 1935. х.2) хэмээн бичсэн нь тухайн нийгмийн захиалга байсан мэт.

Д.Нацагдорж нь монголын уран зохиолд төдийгүй оюун санааны ертөнцөд уран сэтгэмж, нөгөө талаар далд агуулгатай, өөрийх нь тэмдэглэсэнчлэн, хүний ухаанаар ухаж болох гарцаагүй тайлал шаардсан зохиол бүтээлийг бий болгожээ. Тухайлбал «Харанхуй хад» өгүүллэг, судлаач Ч.Жачин “Шинжлэх ухааны чанар буюу үнэн бодит зүйл дээр тулгуурлан хүний сэтгэлд оромгүй бэрхтэй зүйлийг зохиолч өөрийн ухаанаар буюу уран сэтгэмжээр зохиогоод, мөн өөрийн ухаанаар тайлсан болох нь «Харанхуй хад» өгүүллэгт тодорхой байна.”(Дашдоржийн Нацагдоржийн Гар бичмэлийн эх бичгийн судалгаа. 2006. х.131) гэжээ.

Зөвлөлтийн нэрт монголч эрдэмтэн К.Н.Яцковская “Үргэлжилсэн үгийн зохиолын жижиг төрөл зүйлийн талаар Нацагдорж эргэцүүлэн бодож байсныг

«Харанхуй хад» өгүүллэгийнхээ эцэст «Новелла», «Уран сэтгэмжийн өгүүллэг» гэсэн үг бичсэн нь харуулна.” (Дашдоржийн Нацагдорж. 1976. х.57) гэж тэмдэглэжээ. Уран зохиолын онолд уран сэтгэмж буюу фантастика гэдгийг “Урьд нь таньж мэдсэн бодит амьдралын үзэгдэлд үндэслэн ургуулан бодож бүтээсэн ер бусын төсөөлөл дүрслэлийн ертөнц” (Словарь литературведческих терминов.1974. х.137) гэж тодорхойлсон байдаг.

Д.Нацагдорж нь тухайн үеийн нийгмийн хөгжлийнгажуудал, түүний сөрөгүрдагаврыг далд, шүүмжлэлт сэтгэлгээний хэлбэрээр, нүүдлийн өвөрмөц иргэншлийн агуулгыг шинэ сэтгэлгээгээр илэрхийлж чадсан. Энэ утгаар нь “Би хувьдаа Д.Нацагдоржийг хэнд ч хараат бус бие даасан, агуу их зохиолч гэж ойлгосоор ирсэн.” бүтээлдээ дурдсан байдаг (Галбаатар, 2006. х.46).

XX зууны эхээр монголчууд түүхийн шинэ босгон дээр тулж ирсэн. Нүүдлийн соёл иргэншил дэх хүн ба суурин иргэншлийн нөлөөгөөр бий болсон шинэ асуудал, хүн-байгаль, хүн-нийгэм, хуучин ба шинэ, нийгэм ба ёс суртахуун, хот-хөдөө зэрэг ээдрээтэй ойлголт, ялангуяа хүний сэтгэл, хүн чанарын эвдрэл, нийгэм дэх ёс суртахууны уналтыг хөндсөн богино хэлбэрийн зохиолууд бий болсон нь оюун санааны ертөнцөд гарсан томоохон өөрчлөлт байсан юм. Энэ өөрчлөлтийн маналайлагч бол Д.Нацагдорж мөн.

“Олон талын боловсрол олж авсан хийгээд, эрдэм шинжилгээний ажил хийж байсан. Түүнчлэн европын, түүний дотор оросын утга зохиолыг байнга сонирхдог байсан нь Нацагдоржийг феодалын монголын соёлын өвд бодлоготой хянуур хандах хандлагыг нь тодорхойлов.”(Дашдоржийн Нацагдорж. 1976. х.51) гэж түүний үйл хэрэг, үзэл бодлоо илэрхийлсэн уран сайхны амьд цогц дүр бүхий сэтгэл зүйн шинэ хэв маягыг нь дүгнэсэн байна. Түүнчлэн “К.Марксын «Капитал» тэргүүн ботийн хэсгээс, Шинжлэх ухааны хүрээлэнгийн захирлаар ажиллаж байсан Г.Е.Грумм Гржимайлогийн бичсэн «Монголын түүх»-

ээс Д.Нацагдорж орчуулалцан, Марко Поло-гийн жуулчлалын бичгийг Алберт Германы «Их хааны ордонд» гэсэн нэрээр товчлон нийтэлснийг, мөн Д.Покотиловын «Мин улсын үеийн Дорнод Монгол» гэдэг бичиг Хаант Орос улсаас Монгол улсад Элчин сайдаар сууж байсан Кростовецийн германаар бичсэн «Чингис хаанаас Зөвлөлт Бүгд Найрамдах Улс» хүртэл номын зарим бүлгийг герман, орос хэлнээс тус тус хөрвүүлжээ. Энэ бүхэн нь Д.Нацагдорж олон талын эрдэм мэдлэгтэй сэтгүүлч, түүхч, соён гэгээрүүлэгч, орчуулагч байсныг батлан харуулж байна.” (Монголын уран зохиолын дээжис. 1996. х.12) гэжээ.

ДҮГНЭЛТ

Энэ бүхнийг нэгтгэн дүгнэвэл, Д.Нацагдорж нь монголчуудын оюуны соёл, танин мэдэхүйн хөгжилд чухал үүрэг гүйцэтгэсний зэрэгцээ нийгмийн дутагдал, хөгжлийн гажуудал, тэдгээрийг дагасан сөрөг үр дагаврыг олж харан, олон түмний анхаарлыг хандуулж байснаараа шинэ үеийн соён гэгээрүүлэгч мөн юм.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

Галбаатар, Д. (2006). Урлахуйн галыг бадраагч зул эндүүрлийн гэмийг ариусгагч. Улаанбаатар.
Гэндэнсүрэн, Г. (1978). Их зохиолч ертөнцийг хэрхэн үзэж байсан бэ? /Д.Нацагдоржийн уран бүтээлийн тухай/ УБ.
Дашпүрэв, Д. (2005). Монголын нийгмийн өөрчлөлт шинэчлэлтийн үе шатууд. Улаанбаатар
Жачин, Ч.(2006) Дашдоржийн Нацагдоржийн Гар бичмэлийн эх бичгийн судалгаа. Улаанбаатар
Их хааны ордонд. Итал улсын иргэн Марко Полын Төв ба дундад улсаар аялан явсан тэмдэглэл. ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн номын сангийн гар бичмэлийн хөмрөгт
МАХН-ын Төв Архив. Ф.4, Д.2, ХН. 6, Х.104
МАХН-ын Төв Архив. Ф.3, Д.1, ХН. 174, Х.110

МАХН-ын Төв Архив. Д.1, ХН.366, Х.31
Монголын уран зохиолын дээжис. (1996). Улаанбаатар
Наваансүрэн, Д. (1978). Монголын орчин үеийн утга зохиолыг үүсгэн бүтээгч /Д.Нацагдоржийн уран бүтээлийн тухай/ Улаанбаатар
Очир, А. Дашням, Г. (1996). Д.Нацагдорж: нийгэм, улс төр, эрдэм судлалын үйлс, амьдрал. Улаанбаатар
Содном, Б. (1980). Д.Нацагдоржийн зарим уран зохиолын судалгаа. Улаанбаатар
УТТА. Ф.23, Д.2, ХН.9
УТТА. Ф.23, Д.2, ХН.179
УТТА. Д.Нацагдоржийн хувийн фонд, задгай материалд
Zedew, D. (эмх) “он т-бүс” Sekretar des Mongolischen Schriftsteiiver bandes. VII Schrifsteller-Kongres der Deutschen Demokratischen Republik Protokoll (Arbeitsgruppen).
Эдгэр По.(1935). Алтан цох. Улаанбаатар
Энхбаяр, С.(2004). Утга зохиол судлалын шүүмжлэлт өгүүллүүд. Улаанбаатар
Яцковская, К.Н.(1978). Д.Нацагдоржийн орчуулгын ур чадварын тухай асуудалд. /Д.Нацагдоржийн уран бүтээлийн тухай/ Улаанбаатар
Яцковская, К.Н. (1976). Дашдоржийн Нацагдорж. Улаанбаатар
Словарь литературведческих терминов. Москва, 1974. стр 137